



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2024/75/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Даланзадгад хот

2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр  
Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул  
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор: Ж.Болормаа  
Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn

Аудитор: С.Одончимэг  
Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2024.02.23 № 117  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

МАНДАЛ-ОВОО СУМЫН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Д.АДИЛБИШ ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мандал-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Мандал-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөрт төсвөөс хөрөнгө зарцуулсан, он дамжсан өвсний авлага барагдуулаагүй, гэрээ хэлцэл, төсөв тооцоогүй, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ хийж хөрөнгө зарцуулсан, түлээ нүүрсний хөнгөлөлтөөс хувь хүний орлогын албан татвар суутгаагүй, худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг, хувцас худалдан авсан, Засаг даргын нөөц сангаас зориулалт бусаар хөрөнгө зарцуулсан нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.4, 24 дүгээр зүйлийн 24.7, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 15 дугаар зүйлийн 15.1.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 18 дугаар зүйлийн 18.1, Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3, 36.4 дахь заалтууд болон Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 1.2, Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/261 дүгээр тушаалаар баталсан "Хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх, албан татварын хөнгөлөлт эдлүүлэх журам"-ын 2.2-д заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн

016020249

тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Аймгийн Засаг даргын 2023 оны А/792 дугаар захирамжаар Мандал-Овоо сумын 100 жилийн ойн баяр наадмын үйл ажиллагаанд зориулан 100.0 сая төгрөгийн дэмжлэг олгосон байна.

#### **Аудитын гол асуудал**

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Мандал-Овоо сумын төвд 1,880.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дулаан, цэвэр, бохирын шугам сүлжээний өргөтгөлийн ажил хийгдсэн байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Сумын нутаг дахь геодезийн хатуу цэг тэмдэгтийн тооллогын ажлыг 19.5 сая төгрөгөөр хийхээр гэрээ байгуулсан боловч цас их орж хөдөө ажиллах боломжгүй нөхцөл үүссэн шалтгаанаар хойшлогдсон байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>146,185,418.60</u></b>	<b><u>317,677,706.98</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	33,576,000.00	118,781,738.38
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	936,938.38
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	44,386,300.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	19,976,000.00	59,858,500.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	19,976,000.00	59,858,500.00
<b>336</b>	<b>Зээлийн авлага</b>	13,600,000.00	13,600,000.00
<b>3361</b>	<b>Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага</b>	13,600,000.00	13,600,000.00
33612	Хувь хүмүүст олгосон зээл	13,600,000.00	13,600,000.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	-	36,500,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	36,500,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	112,609,418.60	162,395,968.60
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	19,700,000.00	19,700,000.00
35110	Тусгай зориулалттай материал	19,700,000.00	19,700,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	92,909,418.60	142,695,968.60
35410	Бичиг хэргийн материал	794,275.00	794,275.00
35420	Аж ахуйн материал	78,092,143.60	117,936,993.60
35470	Бусад хангамжийн материал	14,023,000.00	23,964,700.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>3,337,634,671.62</u></b>	<b><u>3,901,762,803.22</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	3,337,634,671.62	3,901,762,803.22
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	3,205,414,478.16	3,769,912,609.72
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,409,489,196.83	2,587,391,334.83
39202	Хуримтлагдсан элэгдэл	(359,150,523.53)	(445,191,334.58)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	170,568,684.00	173,968,684.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(90,389,350.37)	(104,944,797.53)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	361,556,897.00	436,290,297.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(185,396,998.23)	(232,833,310.17)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	104,057,232.90	157,885,732.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	(55,971,046.73)	(78,593,942.40)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,011,261,757.13	1,548,331,050.13
39215	Хуримтлагдсан элэгдэл	(209,538,670.84)	(321,318,404.46)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	48,927,300.00	48,927,300.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	132,220,193.46	131,850,193.50
39301	Програм хангамж	3,100,000.00	3,100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,421,666.54)	(2,791,666.50)
39303	Бусад биет бус хөрөнгө	131,541,860.00	131,541,860.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>3,483,820,090.22</u></b>	<b><u>4,219,440,510.20</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>19,472,034.11</u></b>	<b><u>88,989,004.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	19,472,034.11	88,989,004.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	19,472,034.11	88,989,004.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,143,798.11	72,004.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	18,328,236.00	88,917,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	18,328,236.00	88,917,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>3,464,348,056.11</u></b>	<b><u>4,130,451,506.20</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b><u>3,464,348,056.11</u></b>	<b><u>4,130,451,506.20</u></b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	560,970,167.64	560,970,167.64
51101	Өмч: - төрийн	560,970,167.64	560,970,167.64
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	2,639,319,485.02	3,305,422,935.11
51210	Өмнөх үеийн үр дүн	2,639,319,485.02	2,652,647,721.02

51220	Тайлант үеийн үр дүн	-	652,775,214.09
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	264,058,403.45	264,058,403.45
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,464,348,056.11</b>	<b>4,130,451,506.20</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>912,781,937.00</b>	<b>4,193,597,293.32</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>462,661,304.00</b>	<b>985,014,626.52</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>462,661,304.00</b>	<b>985,014,626.52</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	349,081,304.00	765,005,331.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	113,580,000.00	220,009,295.52
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>450,120,633.00</b>	<b>3,208,582,666.80</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>57,615,233.00</b>	<b>2,491,916,866.80</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,002,815.00	2,379,844,945.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,817,418.00	6,246,858.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,795,000.00	95,825,063.80
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>392,505,400.00</b>	<b>716,665,800.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	392,505,400.00	716,665,800.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>705,369,451.32</b>	<b>3,375,633,979.23</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>705,369,451.32</b>	<b>3,375,633,979.23</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>627,066,410.53</b>	<b>3,002,591,517.66</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>166,223,843.48</b>	<b>290,542,885.55</b>
210101	Үндсэн цалин	166,223,843.48	216,231,740.24
210102	Нэмэгдэл	0	74,311,145.31
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>20,687,627.66</b>	<b>35,696,015.89</b>
210201	Тэтгэврийн даатгал	13,141,246.10	24,277,171.59
210202	Тэтгэмжийн даатгал	1,914,945.39	2,856,137.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,501,716.33	2,284,910.22
210204	Ажилгүйдлийн даатгал	375,429.06	565,507.64
210205	Эрүүл мэндийн даатгал	3,754,290.78	5,712,288.64
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>30,790,139.18</b>	<b>40,859,595.50</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,021,244.18	3,376,413.00
210302	Түлш, халаалт	27,768,895.00	35,883,182.50
210303	Цэвэр, бохир ус	0	1,600,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>46,688,101.00</b>	<b>73,551,217.00</b>
210401	Бичиг хэрэг	2,665,200.00	2,101,600.00
210402	Тээвэр, шатахуун	34,090,150.00	30,724,028.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,721,901.00	4,314,609.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,133,200.00	2,360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,077,650.00	6,423,300.00

210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0	27,627,680.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>0</b>	<b>18,154,545.52</b>
210604	Урсгал засвар	0	18,154,545.52
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,707,000.00</b>	<b>11,690,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	4,707,000.00	11,690,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>55,042,830.00</b>	<b>117,717,313.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,042,830.00	117,717,313.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>302,926,869.21</b>	<b>2,414,379,945.20</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	82,929,902.00	2,129,485,645.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	394,000.00	991,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	219,602,967.21	283,902,799.40
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>78,303,040.79</b>	<b>373,042,461.57</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>21,140,236.90</b>	<b>111,501,219.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,497,600.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,642,636.90	111,501,219.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>57,162,803.89</b>	<b>261,541,242.57</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	56,671,205.89	122,541,424.57
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	491,598.00	138,999,818.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>207,412,485.68</b>	<b>817,963,314.09</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>482,456,782.49</b>	<b>165,188,100.00</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	462,456,782.49	74,400.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	20,000,000.00	165,113,700.00
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-275,044,296.81</b>	<b>652,775,214.09</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>450,120,633.00</b>	<b>3,208,582,666.80</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>450,120,633.00</b>	<b>3,208,582,666.80</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>57,615,233.00</b>	<b>2,491,916,866.80</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,002,815.00	2,379,844,945.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,817,418.00	6,246,858.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,795,000.00	95,825,063.80
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>392,505,400.00</b>	<b>716,665,800.00</b>

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	392,505,400.00	716,665,800.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>448,920,633.00</b>	<b>3,097,854,986.80</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>448,920,633.00</b>	<b>3,097,854,986.80</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>370,617,592.21</b>	<b>2,680,426,225.23</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>165,128,446.37</b>	<b>290,212,234.23</b>
210101	Үндсэн цалин	140,836,679.11	215,979,431.52
210102	Нэмэгдэл	23,791,740.90	74,232,802.71
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,758.49	0
210104	Урамшуулал	423,871.63	0
210105	Гэрээт ажлын хөлс	54,396.24	0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>20,735,968.66</b>	<b>36,072,133.70</b>
210201	Тэтгэврийн даатгал	14,112,086.01	24,532,936.59
210202	Тэтгэмжийн даатгал	1,678,069.21	2,886,220.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,318,935.42	2,299,955.22
210204	Ажилгүйдлийн даатгал	329,535.81	580,552.64
210205	Эрүүл мэндийн даатгал	3,297,342.21	5,772,468.64
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>29,616,344.18</b>	<b>40,859,595.50</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,021,244.18	3,376,413.00
210302	Түлш, халаалт	26,595,100.00	35,883,182.50
210303	Цэвэр, бохир ус	0	1,600,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>38,000,011.00</b>	<b>45,923,537.00</b>
210401	Бичиг хэрэг	2,665,200.00	2,101,600.00
210402	Тээвэр, шатахуун	25,402,060.00	30,724,028.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,721,901.00	4,314,609.00
210404	Ном, хэвлэл	0	0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,133,200.00	2,360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,077,650.00	6,423,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,707,000.00</b>	<b>11,690,000.00</b>
210701	Гадаад албан томилолт	0	0
210702	Дотоод албан томилолт	4,707,000.00	11,690,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0	0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>59,500,000.00</b>	<b>119,398,313.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	59,500,000.00	119,398,313.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>52,929,822.00</b>	<b>2,136,270,411.80</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	52,535,822.00	2,135,278,911.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	394,000.00	991,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>78,303,040.79</b>	<b>417,428,761.57</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>21,140,236.90</b>	<b>111,501,219.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,497,600.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,642,636.90	111,501,219.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>57,162,803.89</b>	<b>305,927,542.57</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	56,671,205.89	122,541,424.57
213404	Хөрөнгийн	0	0
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	491,598.00	183,386,118.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>1,200,000.00</b>	<b>110,727,680.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>1,200,000.00</b>	<b>110,727,680.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,200,000.00</b>	<b>110,727,680.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>1,200,000.00</b>	<b>110,727,680.00</b>

223001	Бусад хөрөнгө	0	27,627,680.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,200,000.00	83,100,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-1,200,000.00</b>	<b>-110,727,680.00</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>560,970,167.64</b>	<b>264,058,403.45</b>	<b>2,639,319,485.02</b>	<b>3,464,348,056.11</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	13,328,236.00	13,328,236.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>560,970,167.64</b>	<b>264,058,403.45</b>	<b>2,652,647,721.02</b>	<b>3,477,676,292.11</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
Зарласан ногдол ашиг	0	0	0	0
Тайлант үеийн үр дүн	0	0	652,775,214.09	652,775,214.09
<b>2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>560,970,167.64</b>	<b>264,058,403.45</b>	<b>3,305,422,935.11</b>	<b>4,130,451,506.20</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>766,436,500.00</b>	<b>594,124,375.43</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>738,808,800.00</b>	<b>566,496,695.43</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>720,608,800.00</b>	<b>548,303,183.43</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>386,119,200.00</b>	<b>287,966,121.23</b>
210101	Үндсэн цалин	252,279,000.00	213,733,318.52
210102	Нэмэгдэл	133,840,200.00	74,232,802.71
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>48,264,900.00</b>	<b>35,696,008.70</b>
210201	Тэтгэврийн даатгал	32,820,200.00	24,277,171.59
210202	Тэтгэмжийн даатгал	3,861,200.00	2,856,130.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,089,000.00	2,284,910.22
210204	Ажилгүйдлийн даатгал	772,200.00	565,507.64
210205	Эрүүл мэндийн даатгал	7,722,300.00	5,712,288.64
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>43,711,200.00</b>	<b>40,859,595.50</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,101,800.00	3,376,413.00
210302	Түлш, халаалт	37,009,400.00	35,883,182.50
210303	Цэвэр, бохир ус	1,600,000.00	1,600,000.00

210304	Байрны түрээс	0	0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>43,692,200.00</b>	<b>37,585,645.00</b>
210401	Бичиг хэрэг	2,103,000.00	2,101,600.00
210402	Тээвэр, шатахуун	29,756,800.00	26,690,136.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,203,100.00	4,314,609.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,500,000.00	2,360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,129,300.00	2,119,300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>208,200.00</b>	<b>0</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	208,200.00	0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,840,000.00</b>	<b>0</b>
210604	Урсгал засвар	2,840,000.00	0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>11,307,500.00</b>	<b>11,306,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	11,307,500.00	11,306,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>168,115,600.00</b>	<b>133,898,313.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	168,115,600.00	133,898,313.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>16,350,000.00</b>	<b>991,500.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,350,000.00	0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	991,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>18,200,000.00</b>	<b>18,193,512.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>18,200,000.00</b>	<b>18,193,512.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,200,000.00	18,193,512.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>27,627,700.00</b>	<b>27,627,680.00</b>
223001	Бусад хөрөнгө	27,627,700.00	27,627,680.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>766,436,500.00</b>	<b>594,124,375.43</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>751,436,500.00</b>	<b>594,124,375.43</b>
320001	Орон нутгийн төсвөөс	751,436,500.00	594,124,375.43
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>15,000,000.00</b>	<b>0</b>
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,000,000.00	0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,308,530,748.80</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,308,530,748.80</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,215,223,041.80
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,246,113.00
210101	Үндсэн цалин	2,246,113.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	376,125.00
210201	Тэтгэврийн даатгал	255,765.00
210202	Тэтгэмжийн даатгал	30,090.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,045.00
210204	Ажилгүйдлийн даатгал	15,045.00
210205	Эрүүл мэндийн даатгал	60,180.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8,337,892.00
210402	Тээвэр, шатахуун	4,033,892.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,304,000.00

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	384,000.00
210702	Дотоод албан томилолт	384,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,203,878,911.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,203,878,911.80
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	93,307,707.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	93,307,707.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	93,307,707.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	2,491,916,866.80
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	2,491,916,866.80
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	10,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,389,893,008.80
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	92,023,858.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,729.5 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 3,729.5 сая төгрөгийн алдааг залруулж ажилласан. Үүнд:

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн 122.5 сая төгрөгийн шилжүүлгээр санхүүжилтийн эх үүсвэрийг бууруулаагүй, зарлагын дүнд тохируулах бичилт хийгээгүй тайлагнасан,
- Нэмэлт төсвийн 2,491.9 сая төгрөгийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэж ирүүлээгүй,
- Нэмэлт санхүүжилтийн 100110555408 тоот төрийн сангийн харилцах дансанд орон нутгийн төсвөөс олгосон хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний зардлын 895.5 сая төгрөгийн зарцуулалтын эрхийг 213209 тоот нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардалд нээлгэж ажил гүйлгээг хэрэгжүүлсэн,
- Санхүүгийн үр дүнгийн тайланд цалин, байр ашиглалт, нэг удаагийн тэтгэмж урамшуулал, тээвэр шатахуун, албан томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлын нийт 159.3 сая төгрөгөөр мөнгөн гүйлгээний тайлангаас зөрүүтэй тайлагнасан нь санхүүгийн тайланд тусгагдсан өр төлбөр, авлагын дүнгээр тодорхойлогдоогүй,
- Санхүүгийн байдлын тайланд хувь хүмүүсээс авах авлагыг 5.5 төгрөгөөр, байгууллагад төлөх өглөгийг 18.3 сая төгрөгөөр тус тус илүү илэрхийлсэн,
- Сумын Засаг даргын 2023 оны А/168 дугаар захирамжийн дагуу "Тамгын газрын албан хэрэгцээний автомашины засварын ажлын ӨММОЗДТГ/202320 дугаартай гэрээг байгуулж иргэн С.Амарсанаад 17.0 сая төгрөгийг шилжүүлсэн боловч ажил үйлчилгээг тайлант хугацаанд хүлээж аваагүй, гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллаагүй
- Сумын Засаг даргын 2023 оны А/134 дүгээр захирамжийн дагуу "Мандал-Овоо сумын нутаг дахь геодезийн хатуу цэг тэмдэгтийн тооллогын ажлын ӨММОЗДТГ/202319 дугаартай гэрээг байгуулж 19.5 сая төгрөгийг шилжүүлсэн боловч цас их орж хөдөө

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

ажиллах боломжгүй нөхцөл үүссэн тул гэрээний хугацааг хойшлуулж ажил үйлчилгээг хүлээж аваагүй байна

Аудитаар нийт 214.1 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 15.4 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 100.5 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 98.2 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй төсвийн шууд захирагчид сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлж ажилласан.

### 3.1 Төлбөрийн акт

- Он дамжсан өвс тэжээлийн авлага 14.5 сая төгрөгийг барагдуулаагүй, холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.4 "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

- Сумын ЗД-ын 2023 оны А/34 дүгээр захирамж, байгууллагын даргын 2023 оны А/34 дугаар тушаалаар "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг үндэслэн түлээ, нүүрсний хөнгөлөлт 10 албан хаагчид олгохдоо 0.9 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаагүй байна.

Энэ нь Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/261 дүгээр тушаалаар баталсан "Хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх, албан татварын хөнгөлөлт эдлүүлэх журам"-ын 2.2 "Суутган төлөгч нь хууль тогтоомжид тусгайлан заагаагүй "Хөдөлмөрийн дотоод журам" зэрэг зөвхөн тухайн байгууллагын баримт бичиг, шийдвэрийг үндэслэн олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламжийг албан татвараас чөлөөлөхгүй"д заасантай нийцэхгүй байна.

### 3.2 Албан шаардлага

- Тус сумын түүхт 100 жилийн ойн хүрээнд суманд ажиллаж амьдарч байсан үе үеийн албан хаагчид, ахмадын уулзалт, хүндэтгэлийн арга хэмжээнд 16.5 сая төгрөг, Шинжлэх ухааны мал эмнэлэг, үржлийн алба байгуулагдсаны 100 жилийн ойн арга хэмжээнд 2.7 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5 "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх"-д заасантай тус тус нийцэхгүй байна

- Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалт 3.5 сая төгрөгийн цалинг нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас /213209/ тооцож олгон цалин хөлсний бүрэлдэхүүн оруулж нийгмийн даатгал, татварт хамруулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" 210104 урамшуулал гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- Анхан шатны баримтын бүрдэлгүй, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн ажил үйлчилгээ тодорхойгүй, ажлын тайлан гүйцэтгэлгүй 19.7 сая төгрөгийн зардал гаргаж, төсвийн хөрөнгө зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог, 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

- Засаг даргын 2023 оны А/141 дугаар захирамжаар нөөц сангаас төрийн албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх, эрүүл мэнд, дархлааг дэмжих арга хэмжээний зардалд 6.1 сая төгрөгийг зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 1.2 "Энэ журмын 1.1-д заасан "урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан" гэдгийг жил бүр давтагддаггүй онцгой арга хэмжээ, тохиолдлыг төсвийн зардлын зүйл, арга хэмжээний ангиллын дагуу санхүүжүүлэх боломжгүй нөхцөл байдал гэж ойлгоно"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

- Батлагдсан төсвөөс 1.2 сая төгрөгийн бэлэг, 0.85 сая төгрөгийн өвлийн желитка худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно", 15 дугаар зүйлийн 15.1.5 "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

- Сумын Засаг даргын 2023 оны А/58 дугаар захирамжаар сумын түүхт 100 жилийн ойн уран бүтээлийн ажил гүйцэтгэх арга хэмжээнд 50.0 сая төгрөгийн гэрээг байгуулахдаа төсөв тооцоог үндэслээгүй, сонгон шалгаруулалт зарлаагүй, шууд гэрээ байгуулж хөрөнгө зарцуулж ажилласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4 "хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох", Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 "албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3 "Захиалагч шаардагдаж байгаа үйлчилгээний төсөвт өртгийг тооцохдоо боловсон хүчний мэргэжлийн чиглэл, түвшин, зөвлөхийн ажлын талбайд болон төв байранд ажиллах хугацаа, бичиг хэргийн болон тухайн үйлчилгээнд шаардлагатай бусад зардалд үндэслэсэн байна", 36.4 "Захиалагч ажлын даалгавар бэлтгэж, төсөвт өртгийг тооцоолж гаргасны дараа зөвлөхийн жагсаалтад орох саналаа ирүүлэхийг хүссэн урилгыг өдөр тутмын болон бусад хэвлэлд нийтэлнэ"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг давтан шалгахад өвс тэжээлийн авлага барагдуулаагүй, шилэн дансны тухай хуулийг хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, Төрийн аудитын байгууллагаас өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах" 16.5.6 "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

Илрүүлэлт 1: Аймгийн Засаг даргын 2023 оны А/359, А/2268 дугаар дугаар захирамжаар орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн хандиваар, хөнгөлөлттэй үнээр авч, зээлээр борлуулсан 20.6 сая төгрөгийн өвс, тэжээлийг хувь хүнээс авах авлагаар, худалдан борлуулж аймгийн мал хамгаалах санд төвлөрүүлэх 77.7 сая төгрөгийн өглөгийг тус тус санхүүгийн тайланд тусгаж, тооцоо нийлж ажиллаагүй, өвс тэжээлийн тайланг үнэн зөв хөтлөөгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өвс тэжээлийн орлого, зарлагыг санхүүгийн тайланд холбогдох шийдвэрийг үндэслэн үнэн зөв тайлагнах, санхүүгийн тайланд өр, авлагыг тусгаж, харилцагч бүртээ тооцоо нийлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитыг газарт 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/сая төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс		Залруулагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн гүйцэтгэлийн тайланд орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн 122.5 сая төгрөгийн шилжүүлгээр санхүүжилтийн эх үүсвэрийг бууруулаагүй, зарлагын дүнд тохируулах бичилт хийгээгүй тайлагнасан,	1	122.5			1	122.5	1	122.5				
Нэмэлт төсвийн 2,491.9 сая төгрөгийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэж ирүүлээгүй,	1	2,491.9	1	2,491.9			1	2,491.9				
Нэмэлт санхүүжилтийн 100110555408 тоот төрийн сангийн харилцах дансанд орон нутгийн төсвөөс олгосон хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний зардлын 895.5 сая төгрөгийн зарцуулалтын эрхийг 213209 тоот нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардалд нээлгэж ажил гүйлгээг хэрэгжүүлсэн,	1	895.5			1	895.5	1	895.5				
Санхүүгийн үр дүнгийн тайланд цалин, байр ашиглалт, нэг удаагийн тэтгэмж урамшуулал, тээвэр шатахуун, албан томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлын нийт	1	159.3			1	159.3	1	159.3				

159.3 сая төгрөгөөр мөнгөн гүйлгээний тайлангаас зөрүүтэй тайлагнасан нь санхүүгийн тайланд тусгагдсан өр төлбөр, авлагын дүнгээр тодорхойлогдоогүй,												
Санхүүгийн байдлын тайланд хувь хүмүүсээс авах авлагыг 5.5 төгрөгөөр, байгууллагад төлөх өглөгийг 18.3 сая төгрөгөөр тус тус илүү илэрхийлсэн,	1	23.8			1	23.8	1	23.8				
Сумын Засаг даргын 2023 оны А/168 дугаар захирамжийн дагуу "Тамгын газрын албан хэрэгцээний автомашины засварын ажлын ӨММОЗДТГ/202320 дугаартай гэрээг байгуулж иргэн С.Амарсанаад 17.0 сая төгрөгийг шилжүүлсэн боловч ажил үйлчилгээг тайлант хугацаанд хүлээж аваагүй, гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллаагүй	1	17.0	1	17.0			1	17.0				
Сумын Засаг даргын 2023 оны А/134 дүгээр захирамжийн дагуу "Мандал-Овоо сумын нутаг дахь геодезийн хатуу цэг тэмдэгтийн тооллогын ажлын ӨММОЗДТГ/202319 дугаартай гэрээг байгуулж 19.5 сая төгрөгийг шилжүүлсэн боловч цас их орж хөдөө ажиллах боломжгүй нөхцөл үүссэн тул гэрээний хугацааг хойшлуулж ажил үйлчилгээг хүлээж аваагүй байна	1	19.5	1	19.5			1	19.5				
<b>ДҮН</b>	<b>7</b>	<b>3,729.5</b>	<b>3</b>	<b>2,528.4</b>	<b>4</b>	<b>1,201.1</b>	<b>7</b>	<b>3,729.5</b>				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Он дамжсан өвс тэжээлийн авлага 14.5 сая төгрөгийг барагдуулаагүй, холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.	1	14.5	1	14.5								
Сумын ЗД-ын 2023 оны А/34 дүгээр захирамж, байгууллагын даргын 2023 оны А/34 дугаар тушаалаар "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг үндэслэн түлээ, нүүрсний хөнгөлөлт 10 албан хаагчид олгохдоо 0.9 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаагүй байна.	1	0.9	1	0.9								
Тус сумын түүхт 100 жилийн ойн хүрээнд суманд ажиллаж амьдарч байсан үе үеийн албан хаагчид, ахмадын уулзалт, хүндэтгэлийн арга хэмжээнд 16.5 сая төгрөг, Шинжлэх ухааны мал эмнэлэг, үржлийн алба байгуулагдсаны 100 жилийн ойн арга хэмжээнд 2.7 сая төгрөг тус тус зарцуулсан байна.	1	19.2			1	19.2						
Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалт 3.5 сая төгрөгийн цалинг нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас /213209/ тооцож олгон цалин хөлсний бүрэлдэхүүн оруулж нийгмийн даатгал, татварт хамруулаагүй байна.	1	3.5			1	3.5						
Анхан шатны баримтын бүрдэлгүй, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн ажил үйлчилгээ тодорхойгүй, ажлын тайлан гүйцэтгэлгүй 19.7 сая төгрөгийн зардал гаргаж, төсвийн хөрөнгө зарцуулсан байна.	1	19.7			1	19.7						

Засаг даргын 2023 оны А/141 дугаар захирамжаар нөөц сангаас төрийн албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх, эрүүл мэнд, дархлааг дэмжих арга хэмжээний зардалд 6.1 сая төгрөгийг зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулсан байна.	1	6.1			1	6.1						
Батлагдсан төсвөөс 1.2 сая төгрөгийн бэлэг, 0.85 сая төгрөгийн өвлийн желитка худалдан авсан байна.	1	2.05			1	2.05						
Сумын Засаг даргын 2023 оны А/58 дугаар захирамжаар сумын түүхт 100 жилийн ойн уран бүтээлийн ажил гүйцэтгэх арга хэмжээнд 50.0 сая төгрөгийн гэрээг байгуулахдаа төсөв тооцоог үндэслээгүй, сонгон шалгаруулалт зарлаагүй, шууд гэрээ байгуулж хөрөнгө зарцуулж ажилласан байна.	1	50.0			1	50.0						
Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг давтан шалгахад өвс тэжээлийн авлага барагдуулаагүй, шилэн дансны тухай хуулийг хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, Төрийн аудитын байгууллагаас өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	0							1	1		
Аймгийн Засаг даргын 2023 оны А/359, А/2268 дугаар дугаар захирамжаар орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн хандиваар, хөнгөлөлттэй үнээр авч, зээлээр борлуулсан 20.6 сая төгрөгийн өвс, тэжээлийг хувь хүнээс авах авлагаар, худалдан борлуулж аймгийн мал хамгаалах санд төвлөрүүлэх 77.7 сая төгрөгийн өглөгийг тус тус санхүүгийн тайланд тусгаж, тооцоо нийлж ажиллаагүй, өвс тэжээлийн тайланг үнэн зөв хөтлөөгүй байна.	1	98.2					1	98.2				
<b>Дүн</b>	<b>10</b>	<b>214.1</b>	<b>2</b>	<b>15.4</b>	<b>6</b>	<b>100.55</b>	<b>1</b>	<b>98.2</b>	<b>1</b>	<b>1</b>		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны сайтад 12 мэдээлэл хоцроосон, тухайн жилийн төсөв, аудитын дүгнэлтийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлт, 5 сая төгрөгөөс дээш орлогын 1,695.6 төгрөгийн 34 ажил гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш зарлагын 421.4 сая төгрөгийн 21 ажил гүйлгээ, хөрөнгө зарцуулсан шийдвэрийн 47.5 сая төгрөгийн 3 гүйлгээ, 199.9 сая төгрөгийн гэрээний үнэтэй 3 ажлын тендерийн ерөнхий мэдээлэл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг тус тус мэдээлээгүй байна.	1	1			1	1		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>	<b>1</b>		